

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Энэ долоо хоног ОУДС-ийн хамт олон бидний хувьд амжилттай дуусч байна. Өчигдөр орой манай сургуулийн жилийн ерөнхий хуралдаан болж өнгөрлөө. Сургуулийн удирдах зөвлөл, нийт багш ажилчид болон хувиасаа хуралд ирж оролцсон та бүхэнд би талархал илэрхийлье. Удирдах Зөвлөлд шинээр сонгогдсон хүмүүсийн нэрсийг бид өнөөдөр та нарт хүргэх болно.

Лхагва гарагт манай сувилагч Сараа эмчийн хамт клиник өрөөндөө ханиадны эсрэг вакцины тарилга хийлээ. Клиник өрөөнд шаардлагатай багаж төхөөрөмж, эм, бусад хэрэгслийг бид худалдаж авч байна. Ирэх 7 хоногийн төгсгөл гэхэд клиник бүрэн хүчин чадлаараа ажиллах болно.

Би та бүхнийг ЭБЗ-ийн ажилд идэвхтэй оролцохыг уриалж байна. ЭБЗ-ийн хамт олон хандив босгож сургуулийн үйл ажиллагаанд болон бусад төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэ 7 хоногт ЭБЗ 5-р ангийн сурагчдын боловсруулсан төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргалаа. Эдгээр төслүүд нь ИВ хөтөлбөрийн сургалтын агуулгыг дэмжихэд чиглэгдсэн төслүүд юм. Та бүхний тусламжтайгаар бид бусад олон төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх болно. Та бүхэн ЭБЗ-ийн гишүүдтэй холбоо барьж энэ арга хэмжээнд оролцоорой.

Олон Улсын 7 Хоногийн Арга Хэмжээнүүд

Бид уламжлал ёсоор ирэх долоо хоногт олон улсын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна. Эцэг эхчүүд та бүхнийг Даваа, Баасан гарагуудад болох сургуулийн өдөрлөгт болон Пүрэв гарагт болох олон үндэстний хоолны өдөрлөгт оролцохыг урьж байна. Багш нар бага дунд сургуулийн сурагчдын дунд 7 хоногийн турш бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

12-ны Даваа гарагийн 8:30 – “Монголын Өдөрлөг” Заланд болно

Энэ өдөр бүх багш сурагчид Монгол үндэсний хувцас өмсөнө.

15-ны Пүрэв гарагийн 18:30-20:00 – **Олон Үндэстний Хоолны Өдөрлөг болно.** Хавсралт хуудсыг уншаарай.

16-ны Баасан гарагийн 8:30 – **Олон Үндэстний Парад Өдөрлөг** заланд болно. Бүх багш, сурагчид өөрсдийн үндэсний хувцсаа өмсөнө.

Манай намрын амралт 10 сарын 17-ны Бямба гарагт эхэлнэ. Сурагчид 10 сарын 28-ны Лхагва гарагт хичээлдээ орно. Амралтын дараах долоо хоногийн Даваа, Мягмар гарагт багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалттай. 10 сарын 28-ны Лхагва гарагт хичээл ороход та бүхэнтэй уулзацгаая.

**Захирал
Greg Rayl**

Машины Зогсоолын Аюулгүй байдлын талаар

Машины зогсоолын аюулгүй байдлыг хангахад та бүхний тусламж бидэнд хэрэгтэй байна. Дараах хэдэн зүйлсийг та бүхэн сайтар анхаарна уу:

- Машинаас сурагчдыг буулгахаас өмнө зогсоолд машинаа байрлуулах.
- Машины зогсоол дээр хөдөлгөөн дунд машинаа бүү зогсоо. Ингэж гэнэт зогсох нь хөдөлгөөнд саад болоод зогсохгүй сурагчдад аюултай.
- Машины зогсоол дээр сурагчид явж байдаг тул 20 км хурдтай яваарай.

Хүүхдүүдийг тань сургуульд нь хүргэдэг жолооч нартаа та бүхэн машины зогсоол дээрх хөдөлгөөний аюулгүй байдлыг сайтар дагаж мөрдөхийг анхааруулна уу. Та бүхэнд баярлалаа.

Лэд Захирал Түүд Ардлий

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Монголд цаг агаар хуурайшилт ихтэй тул хүүхдүүд ус их уух хэрэгтэй гэдгийг би дахин сануулъя. Шингэн дутагдсанаас болж толгой өвдөх нь хичээл хийхэд нь сурагчдад хүндрэлтэй байх болно. Хүүхэддээ өдөр бүр усны савыг нь цэвэрлэж өгч явуулаарай.

1-р улирал дуусах дөхөж сурагчид сайн суралцаж байна. Амралт эхэлтэл сайн хичээгээрэй. Ирэх долоо хоногт олон улсын өдрүүдийн үеэр ч гэсэн сурагчдад үзэж судлах зүйлс их байгаа. Бид бүгдээрээ хичээж байж сурагчид маань амжилттай дүн үзүүлнэ.

Олон улсын 7 хоногийн өдрүүдээр бид бүхэн үндэсний хувцсаа өмсөж, өөрсдийн соёл, зан заншлаас бусадтайгаа хуваалцдаг. 10 сарын 15-ны Пүрэв гарагт бид олон үндэстний хоолны өдөрлөг зохионо. Та бүхэн ЭБЗ-ийн гишүүдтэй холбоо барьж ямар хоол хийж авчрах тухайгаа ярилцаарай. Энэ өдөрлөгийн үеэр бид та бүхэнтэй уулзана. Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч
Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Олон улсын 7 хоног: Даваа гарагт бүх сурагчид Монгол үндэсний хувцастай, Баасан гарагт өөрсдийн үндэсний хувцастай хичээлдээ ирнэ.

5-р анги: 10 сарын 6-ны Мягмар гарагт ЭБЗ-ийн гишүүд хуралдаж Баян Зүрх Дүүргийн гэр хороололд хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргалаа. Энэ хуралд 5-р ангийн сурагчид оролцлоо. 5-р ангийн сурагчдын боловсруулсан 5 төслөөс 2 төслийг нь нэг сая төгрөгөөр санхүүжүүлэх шийдвэрийг ЭБЗ гаргалаа. Нэг төсөл нь яаралтай тусламж хэрэгтэй гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх, нөгөө төсөл нь тогтвортой хөгжлийг дэмжих төслүүд байлаа.

ЭБЗ-ийн 22 гишүүн санал хураалтанд оролцож 2 айлын гэрийн бүрээсийг давхарлаж, хаалгыг нь солих, Цэцэглэх Ирээдүй төвд Ногоон Хүлэмж барьж өгөх төслүүдийг тус тус санхүүжүүлэхээр боллоо.

5-р ангийн сурагчид ЭБЗ-ийн хамт олонд талархал илэрхийлж төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хандивыг цуглуулах шийдвэр гаргалаа. Хичээлийн жилийн туршид бид хандив цуглуулах ажлын явцыг болон Баян Зүрх дүүрэгт зочилсон тухайгаа та бүхэнд мэдээлж байх болно.

Бэлтгэл ангийн Өдөрлөг: Энэ улирлалд үзсэн цагаан толгойн үсэгнүүдээ оролцуулж өөрсдийн зохиосон түргэн хэллэгүүдийг бэлтгэл ангийхан бусаддаа сонирхууллаа. Тэд бас “Ten Green Bottles” дууг хөдөлгөөн оруулж дуулж сонирхууллаа.

Хичээлээс гадуурх аялал: 3-р ангийн сурагчид эртний болон өнөөгийн хүмүүсийн тоглодог тоглоомууд сэдэвт хичээлийн дагуу Монголын Түүхийн Музейг үзэж сонирхлоо.

Бага Сургуулийн Эрхлэгч
Jan Wiggins

БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

Энэ сарын сүүлчээр Нинбо хотноо болох ACAMIS волейболын тэмцээнд оролцох охидын баг Америкийн дунд сургуулийн багтай тоглолоо. Тэмцээн өрсөлдөөнтэй болж охидын баг 2:1-ийн харьцаатай хожлоо. (25-22, 25-19, 14-25) ОУДС-ийн багт 14 охид тоглосон. Тэдний ихэнх нь анх удаагаа үзэгчдийн өмнө гарч тэмцээнд оролцож тоглолоо.

Хөвгүүдийн баг тамирчид бэлтгэлээ амжилттай хийж багийн тоглолтын стратегит суралцаж байна. Хөвгүүдийн баг бас удахгүй Америкийн Дунд Сургуулийн багтай тоглох болно.

Бэлтгэлийн хуваарь:

Охидын баг Мягмар, Пүрэв гарагуудад 4:00-5:30

Хөвгүүдийн баг Лхагва гарагт 4:00-5:30, Бямба гарагт 1:00-3:00

9-12-р ангийн охидын волейболын тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Багийн ахлагчид багуудаа сайн зохион байгуулж оролцсон. Охидууд 8 сараас эхлэн сайн бэлтгэл хийсний үр дүнд бөмбөг давуулах тал дээр их сайжирсан байна.

Тоглолтын оноо:

Цэнхэр баг	Ногоон баг	25-19	Улаан баг	Шар баг	22-25
------------	------------	-------	-----------	---------	-------

Цэнхэр баг	Улаан баг	25-20	Ногоон баг	Шар баг	11-25
------------	-----------	-------	------------	---------	-------

Цэнхэр баг	Шар баг	11-25	Улаан баг	Ногоон баг	19-25
------------	---------	-------	-----------	------------	-------

Багуудын нийлбэр дүн:

1. Шар баг 3 тоглож 3 хожиж нийт 6 оноотой
2. Цэнхэр баг 3 тоглож 2 хожиж, 1 хожигдож нийт 4 оноотой
3. Ногоон баг 3 тоглож 1 хожиж, 2 хожигдож нийт 2 оноотой
4. Улаан баг 3 тоглож 3 хожигдож оноо аваагүй байна.

10 сарын 10-ны Бямба гарагт сургууль дээр SAT шалгалттай тул спортын тэмцээн болохгүй. Хөвгүүдийн багийн бэлтгэл цагтаа болно.

Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч
David Ricketts